

АПУ ХК-ийн Төлөөлөн удирдах
зөвлөлийн 2019 оны 02 дүгээр
сарын 17-ны өдрийн 17/0 тоот
тогтоолын 2-р хавсралтаар батлав

АПУ ХК-ААС БАРИМТЛАХ ДОТООД АУДИТЫН БОДЛОГО

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү баримт бичгийг Монгол Улсын Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн засаглалын кодексийн хүрээнд нээлттэй хувьцаат компанийн үйл ажиллагаанд тавигдах шаардлагад нийцүүлэн боловсруулав.
- 1.2. Энэхүү бодлогын зорилго нь АПУ ХК (цаашид “компани” гэх)-ийн үйл ажиллагааг үнэлэх, сайжруулах, түүний үнэ цэнийг нэмэгдүүлэхэд чиглэсэн хараат бус, бие даасан, бодитойгоор баталгаа өгөх ба зөвлөх үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Хоёр. Дотоод аудит

- 2.1. Дотоод аудит гэж компанийн үйл ажиллагааг үнэлэх, сайжруулах, түүний үнэ цэнийг нэмэгдүүлэхэд чиглэсэн хараат бус, бие даасан, бодитойгоор баталгаа өгөх ба зөвлөх үйл ажиллагааг ойлгоно.
- 2.2. Компани нь бүхий л түвшинд эрсдэлд суурилсан дотоод аудитын үйл ажиллагаа явуулах бөгөөд дотоод аудит нь дараах чиглэлтэй байна. Үүнд:
 - 2.2.1. Компанийн засаглалын үйл явцыг үнэлэх, сайжруулах зөвлөмж өгөх;
 - 2.2.2. Эрсдэлийн удирдлагын үйл явцын үр нөлөөтэй байдлыг үнэлэх, сайжруулах;
 - 2.2.3. Дотоод хяналтын системийн үр нөлөөтэй ба үр ашигтай байдалд үнэлгээ хийх, тэдгээрийн байнгын сайжруулалтанд дэмжлэг үзүүлэх, баталгаа гаргах;
 - 2.2.4. Санхүүгийн үйл ажиллагаа болон тогтолцооны зөв найдвартай ажиллагааг үнэлэх, сайжруулах зөвлөмжийг өгөх;

Гурав. Дотоод аудитын зарчим

- 3.1. Дотоод аудитыг гүйцэтгэхэд дараах зарчмыг баримтална. Үүнд:
 - 3.1.1. **Шударга байх:** Дотоод аудиторын шударга байдал нь “итгэл”-ийг бий болгох ба тэдний гаргасан дүгнэлтэд тулгуурлах үндэслэл болно.
 - 3.1.2. **Бодитой байх:** Дотоод аудитор мэдээлэл цуглуулах, үнэлэх, танилцуулахдаа бодитой байх хандлагыг баримтална. Шийдэл гаргахдаа

гадны нөлөө болон өөрийн ашиг сонирхлын нөлөөг оруулахгүйгээр холбогдох нөхцөл байдлыг тэнцвэртэй үнэлнэ.

- 3.1.3. **Нууцыг хадгалах:** Дотоод аудитор олж авсан мэдээллийн үнэ цэнэ, өмчлөлд хүндэтгэлтэй хандан, хуулиар хүлээсэн эсвэл мэргэжлийн хувьд хүлээсэн үүрэг хариуцлагаас бусад тохиолдолд зөвшөөрөлгүйгээр бусдад дэлгэхгүй.
- 3.1.4. **Ур чадвартай байх:** Дотоод аудитор ажлаа гүйцэтгэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар, туршлагатай байна.

Дөрөв. Дотоодын аудитын үйл явц

- 4.1. Дотоод аудитын үйл явц нь дараах үе шаттайгаар хэрэгжинэ. Үүнд:
 - 4.1.1. Төлөвлөх;
 - 4.1.2. Гүйцэтгэх;
 - 4.1.3. Тайлагнах;
 - 4.1.4. Эргэн хянах;
 - 4.1.5. Хяналт, мониторинг хийх;

Тав. Дотоод аудитын хэрэгжүүлэлт

- 5.1. Дотоод аудитыг компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид "ТУЗ" гэх), түүний дэргэдэх Аудитын хороо, ТУЗ-өөс томилогдсон Дотоод аудитын баг хэрэгжүүлэх ба Гүйцэтгэх удирдлага нь дэргэдээ дотоод аудит хэрэгжүүлэх нэгжтэй байж болно.
- 5.2. Төлөөлөн удирдах зөвлөл нь дараах байдлаар дотоод аудитын үйл ажиллагааг хариуцна.
 - 5.2.1. Дотоод аудитын бодлогыг тодорхойлох, батлах, түүнийг өөрчлөн сайжруулах;
 - 5.2.2. ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны саналаар Дотоод аудитын баг (*орон тооны болон орон тооны бус эсхүл хөндлөнгийн аудит аль ч хэлбэрээр байж болно*)-ийн удирдлага, ажилтныг томилох, тэдгээрийн цалин урамшууллыг тогтоох;
 - 5.2.3. Эрсдэлд суурилсан дотоод аудитын дунд хугацааны төлөвлөгөөг боловсруулах, батлах, гүйцэтгэлийг хянах;
 - 5.2.4. Дотоод аудитын багийн ажиллах журам, дүрмийг батлах;
 - 5.2.5. Дотоод аудитын багийн ажлыг дүгнэх
- 5.3. Дотоод аудитын баг нь дараах байдлаар дотоод аудитын үйл ажиллагааг хариуцна.
 - 5.3.1. Компанийн өндөр эрсдэлтэй хэсгүүдэд чиглэн ажиллах;
 - 5.3.2. Дотоод аудитын үйл ажиллагааг Монгол Улсын хууль тогтоомжийн хүрээнд Дотоод аудиторын олон улсын институтийн баталсан стандартын дагуу гүйцэтгэх;



- 5.3.3. Дотоод аудитын үйл ажиллагааны тайланг Төлөөлөн удирдах зөвлөлд тайлагнах;
- 5.4. Гүйцэтгэх удирдлага нь дараах байдлаар дотоод аудитын үйл ажиллагааг хариуцна.
- 5.4.1. Дотоод аудитын нэгж байгуулах, түүний ажиллах журам, дүрмийг боловсруулах, батлах, хэрэгжүүлэх;
- 5.4.2. ТУЗ-өөс батлагдсан дотоод аудитын дунд хугацааны төлөвлөгөөнд үндэслэн жилийн болон ажлын төлөвлөгөөг боловсруулах, батлах, хэрэгжүүлэх;
- 5.4.3. Дотоод аудитын нэгж нь хууль тогтоомж, батлагдсан бодлого, дүрэм, журам, стандартын дагуу дотоод аудитыг гүйцэтгэх;
- 5.4.4. Дотоод аудитын үйл ажиллагааны тайланг Гүйцэтгэх удирдлагад тайлагнах;
- 5.4.5. Дотоод аудитын нэгжийн ажлыг дүгнэх;

Зургаа. Хяналт, сайжруулалт, өөрчлөлт оруулах

- 6.1. Хөндлөнгийн аудитаас дотоод аудитын үйл ажиллагаанд гарсан үнэлэлт, дүгнэлтийн дагуу дотоод аудитын үйл ажиллагааг сайжруулна.
- 6.2. Дотоод аудитын мэргэжил практикийн олон улсын стандартын өөрчлөлт, хөндлөнгийн аудитын дүгнэлт, Төлөөлөн удирдах зөвлөл, түүний дэргэдэх Аудитын хорооны Гүйцэтгэх удирдлагын саналд үндэслэн дотоод аудитын бодлогод өөрчлөлт оруулна.